



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 37 (322)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай
- Орон сууцны барилгыг эзэмшиүүлэх тухай
- Монгол Улсын төсвийн орлого, зарлагын ангилал батлах тухай

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2003 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2003 оны аравдугаар сарын 8

№ 37 (322)

## Гарчиг

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

|      |  |            |     |
|------|--|------------|-----|
| 527. | Тогтоолд өөрчлөлт оруулах тухай  | Дугаар 155 | 845 |
| 528. | Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих<br>хетелбериийн хэрэгжилтийг зөрчимжуулэх<br>талаар авах зарим арга хэмжээний<br>тухай | Дугаар 188 | 846 |
| 529. | Орон сууцны барилгыг эзэмшүүлэх тухай  | Дугаар 199 | 850 |
| 530. | Тогтоолд өөрчлөлт оруулах тухай  | Дугаар 201 | 850 |
| 531. | Монгол Улсын төсвийн орлого, зарлагын<br>ангилал батлах тухай  | Дугаар 203 | 851 |

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 6 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 155

Улаанбаатар  
хот

#### Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ  
ны:

"Засгийн газрын Хүндэт өргөмжлэл,  
гэрчилгээний тодорхойлолт, дүрэм батлах тухай"

Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 19-ний  
өдрийн 51 дүгээр тогтоопын 2 дугаар хавсралтаар  
баталсан "Монгол Улсын Засгийн газрын Хүндэт  
өргөмжлэлийн тухай дүрэм"-ийн "Хоёр" дахь хэсгийн  
3 дугаар заалтыг "З. Монгол Улсын Засгийн газрын

Хүндэт өргөмжлелеер шагнагдсан Монгол Улсын  
болон гадаадын иргэнд 500.000 (таван зуун мянган)  
төгрөгийн дагалдах менген шагнал олгоно." гэж  
өөрчлөн найруулсугай.

Монгол Улсын  
өрөөнхий сайд

Н. Энхбаяр

Засгийн газрын гишүүн,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга

Ө.ЭНХТҮҮВШИН



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 8 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 188

Улаанбаатар  
хот

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих  
хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх  
талаар авах зарим арга хэмжээний тухай

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих  
хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх  
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх  
чиглэл"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Түгээмэл хэрэглэгдэг технологиор  
бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортыг орлох  
бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,  
хүнсний болон өргөн хэрэглээний барааны жижиг  
үйлдвэрүүдийг орон нутагт өргөжүүлэх чиглэлээр  
Монгол банк, арилжааны банкуудтай хамтран  
хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, шаардлагатай тоног  
техникээр лизингээр худалдан авч ашиглах  
механизм бурдуулэх арга хэмжээ авахыг Үйлдвэр,  
худалдааны сайд Ч.Ганзориг, Хүнс, хөдөө аж ахуйн  
сайд Д.Насанжаргал нарт давласугай.

3. Хавсралтад заасан чиглэлийн дагуу  
жижиг дунд үйлдвэрүүдийг орон нутагт хөгжүүлэх  
хөдөлгөөн өргүүлж, санаачилга гаргасан хөрөнгө  
оруулагч, бизнес эрхлэгчдийг үйл ажиллагаанд  
дэмжэг үзүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга  
нарт үүрэг болгосугай.

4. Дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний  
тэргүүн эзлжинд төсвийн байгууллагуудын  
хэрэгжээнд ашиглах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх  
эрх зүйн таатай нөхцөл бурдуулэх чиглэлээр

холбогдох хууль тогтоомжид нэмэлт, веерчлелт  
оруулах санал боловсруулж Засгийн газарт  
танилцуулахыг Санхүү, эдийн засгийн сайд  
Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг  
нарт давласугай.

5. Лизингийн тоног төхөөрөмжийн нийгмийн  
ач холбогдлыг харгалzan унийн дүнгийн 25 хувь  
хүртэл хэмжээнд Засгийн газраас дэмжлэг үзүүлэх  
боловмжийг судлах, хэрэгжүүлэх талаар арга  
хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд  
Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг,  
Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал нарт  
даалгаж, Монгол банкны еренхийлгэг  
О.Чулуунбатад зөвлөсүгэй.

Монгол Улсын  
Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Санхүү, эдийн  
засгийн сайд

Ч.УЛААН

Үйлдвэр, худалдааны  
сайд

Ч.ГАНЗОРИГ

Хүнс, хөдөө аж  
ахуйн сайд

Д.НАСАНЖАРГАЛ

Засгийн газрын 2003 оны 188 дугаар  
тогтооолын хавсралт

## ОРОН НУТАГТ ҮЙЛДВЭРЛЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Түүхий эдийн неец, боломжид тулгуурлан  
хүнсний болон өргөн хэрэглээний барааны  
үйлдвэрлэлийг орон нутагт хөгжүүлэх, экспортын  
баримжаатай болон импортыг орлох  
бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар  
хөдөөгийн хүн амын амьжиргааны түвшинт  
дээшшуулэх, алжны байр нэмэгдүүлэх зорилтыг  
хангахад "Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх  
чиглэл"-ийн зорилго оршино.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал  
тухайн орон нутгийн хэрэгцээ, шаардлагыг  
харгалзан орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэхэд  
дараах чиглэлийг баримтална:

1/Бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлалтай  
үялдуулан хөгжүүлэх үйлдвэрлэл

Бүсийн тулгуур төвүүдэд хөдөө аж ахуйн  
түүхий эд боловсруулах, экспортын баримжаатай  
үйлдвэрлэлийг байршуулах, импортыг орлох  
бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бий болгох, зарим  
нутаг дэвсгэрт аж үйлдвэрийн парк байгуулах  
замаар үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. Бүсийн хөгжилд  
нелөө бүхий, ажиллаж байсан болон ажиллаж  
байгаа үйлдвэрүүдийг сэргээх, хүч чадлыг  
нэмэгдүүлэх, өргөтгэх, шинээр байгуулахад  
дараах чиглэлийг баримтална:



| Бүсийн нэр  | Аймгийн нэр | Авах арга хэмжээний чиглэл                        |  |   |
|-------------|-------------|---|--|---|
|             |             | Сэргээх боломжтой                                 | Хүч чадлын ашиглалтыг нэмэгдүүлэх, ерөтгөх | Шинээр байгуулах гол чиглэл   |
| Баруун бүс  | Баян-Өлгий  | Ноос боловсруулах ўйлдвэр                         | -  | Уул уурхайн ўйлдвэр   |
|             | Говь-Алтай  | -   | Ноолуур боловсруулах ўйлдвэр               | Уул уурхайн ўйлдвэр   |
|             | Завхан      | Мод, модон здлэлийн ўйлдвэр                       | Мах боловсруулах ўйлдвэр                   | Ноос, ноолуур боловсруулах ўйлдвэр  |
|             | Үвс         | Малын тэжээл, чацарагна боловсруулах ўйлдвэр      | Жамц давс боловсруулах ўйлдвэр             | Мах боловсруулах ўйлдвэр  |
|             | Ховд        | -   | -  | Аж ўйлдвэрийн парк  |
| Хангайн бүс | Архантай    | -   | -  | Сарлагийн хөөвөр, жимс жимсгэнэ боловсруулах ўйлдвэр                          |
|             | Баянхонгор  | Хүрмэн түлдмийн ўйлдвэр                           | -  | Уул уурхай, ноолуур, тэмээний ноос боловсруулах ўйлдвэр                       |
|             | Булган      | Мод, модон здлэлийн ўйлдвэр                       | Газар тариалан                             | Оёмол бүтээгдэхүүний ўйлдвэр  |
|             | Орхон       | -   | Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний ўйлдвэр      | Аж ўйлдвэрийн парк  |
|             | Өвөрхангай  | -   | Барилгын материалын ўйлдвэр                | Уул уурхай, мах, махан бүтээгдэхүүний ўйлдвэр                                 |
| Төвийн бүс  | Хөвсгөл     | -   | Мод, модон здлэлийн ўйлдвэр                | Уул уурхай, загас боловсруулах ўйлдвэр  |
|             | Говьсумбэр  | -   | -  | Аж ўйлдвэрийн парк  |
|             | Дархан-Уул  | Барилгын материалын ўйлдвэр                       | -  | Аж ўйлдвэрийн парк  |
|             | Дорноговь   | -   | -  | Уул уурхай, тэмээний ноос боловсруулах, оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний ўйлдвэр |
|             | Дундговь    | -   | -  | Ноос боловсруулах ўйлдвэр   |
| Зүүн бүс    | Дорнод      | -   | -  | Аж ўйлдвэрийн парк  |
|             | Хэнтий      | -   | Уул уурхайн ўйлдвэр                        | Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний ўйлдвэр   |
|             | Сүхбаатар   | Барилгын материалын ўйлдвэрлэл, тэжээлийн ўйлдвэр | -  | Уул уурхайн ўйлдвэр   |

## 2/ Хүнсний ўйлдвэрлэл

Орон нутгийн хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний одоо ажиллаж байгаа ўйлдвэрүүдийн жигд ажиллагааг хангахад дэмжлэг

үзүүлж, доорхи төрлийн бүтээгдэхүүний хүнсний жижиг ўйлдвэрүүдийг шинээр байгуулах чиглэл баримталж, импортыг орлох бүтээгдэхүүний ўйлдвэрэлтийг нэмэгдүүлнэ:



| Бүсийн нэр  | Аймгийн нэр | Бутзэгдэхүүний нэр төрөл, жилийн хүч чадал |              |                          |                               |                    |                            |
|-------------|-------------|--|--------------|--------------------------|-------------------------------|--------------------|----------------------------|
|             |             | Мах, махан бутзэгдэхүүн мян.тн             | Гурил мян.тн | Талх, нарийн боов мян.тн | Сүү, сүүн бутзэгдэхүүн мян.тн | Цэцгийн тос мян.тн | Тэмс, хүнсний ногоо мян.тн |
| Баруун бус  | Баян-Өлгий  | 35.0                                       | -            | 0.6                      | 1.0                           | -                  | 1.0                        |
|             | Говь-Алтай  | 25.0                                       | 3.0          | 0.03                     | 1.0                           | 0.1                | 0.8                        |
|             | Завхан      | -  | 5.0          | 0.05                     | 1.0                           | 0.25               | 0.8                        |
|             | Увс         | 35.0                                       | -            | 0.5                      | 1.0                           | 0.2                | 0.8                        |
|             | Ховд        | 30.0                                       | 5.0          | 0.5                      | 1.0                           | 0.15               | 1.5                        |
|             | Дун         | 125.0                                      | 13.0         | 1.68                     | 5.0                           | 0.7                | 4.9                        |
| Хангайн бус | Архангай    | 25.0                                       | -            | 0.35                     | 1.0                           | 0.45               | 0.5                        |
|             | Баянхонгор  | 30.0                                       | -            | 0.4                      | 1.0                           | 0.3                | 0.4                        |
|             | Булган      | 20.0                                       | -            | 0.1                      | 1.0                           | 0.3                | 0.5                        |
|             | Орхон       | -  | -            | 0.5                      | 2.0                           | -                  | 0.6                        |
|             | Өвөрхангай  | -  | -            | 0.35                     | 1.0                           | 0.15               | 0.5                        |
|             | Хөвсгөл     | 40.0                                       | -            | 0.6                      | 1.0                           | 0.4                | 0.8                        |
|             | Дун         | 115.0                                      | -            | 2.3                      | 6.0                           | 1.6                | 3.3                        |
| Төвийн бус  | Говьсумбер  | 10.0                                       | -            | 0.1                      | -                             | -                  | 0.5                        |
|             | Дархан-Ул   | -  | -            | -                        | -                             | 0.05               | 2.0                        |
|             | Дорноговь   | -  | -            | 0.2                      | 1.0                           | -                  | 1.5                        |
|             | Дундговь    | 20.0                                       | -            | 0.1                      | 1.0                           | -                  | 0.2                        |
|             | Өмнөговь    | 20.0                                       | -            | 0.1                      | 1.0                           | -                  | 1.0                        |
|             | Сэлэнгэ     | 70.0                                       | -            | -                        | 2.0                           | -                  | 2.0                        |
|             | Төв         | 20.0                                       | -            | 0.25                     | 1.0                           | 0.05               | 2.0                        |
|             | Дун         | 140.0                                      | -            | 0.75                     | 6.0                           | 0.1                | 9.2                        |
| Зүүн бус    | Дорнод      | -  | -            | 0.5                      | 1.0                           | 0.15               | 0.8                        |
|             | Хэнтий      | 20.0                                       | -            | 0.25                     | 1.0                           | 0.1                | 1.0                        |
|             | Сүхбаатар   | 30.0                                       | -            | 0.6                      | 1.0                           | 0.1                | 0.4                        |
|             | Дун         | 50.0                                       | -            | 1.35                     | 3.0                           | 0.35               | 2.2                        |
| Бугд        |             | 430.0                                      | 13.0         | 6.08                     | 20.0                          | 2.75               | 19.6                       |

Гурил үйлдвэрлэх, сүү, сүүн бутзэгдэхүүн боловсруулах, жимс жимсгэнэ, темс, хүнсний ногоо боловсруулах, невшлех, савлах, малын тэжээл, ёвс, хадлан бэлтгэх, баглах үйлдвэрүүдэд түгээмэл хэрэглэгддэг технологи ашиглах зорилт тавина.

Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангасан бутзэгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, нэр төрлийг олшруулахад анхаарна.

З/Өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэл

Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг орон нутагт нь боловсруулахад анхаарч, хүн амын өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийг аймаг, сумдын төв рүү чиглүүлнэ. Дараах өргөн хэрэглээний барааны жижиг үйлдвэрүүдийг орон нутагт хөгжүүлэх чиглэл баримтална:



| Бүсийн нэр  | Аймгийн нэр | Бүтээгдэхүүний төрөл, жилийн хүч чадал |                        |                      |                       |                          |
|-------------|-------------|--|------------------------|----------------------|-----------------------|--------------------------|
|             |             | Эсгий, эсгий эдлэл мян. шир            | Сүлжмэл эдлэл мян. шир | Оёмол эдлэл мян. шир | Савхин гутал мян. хос | Мод, модсн эдлэл сая.төг |
| Баруун бүс  | Баян-Өлгий  | -                                      | 5.0                    | 10.0                 | 5.0                   | -                        |
|             | Говь-Алтай  | -                                      | 12.0                   | 73.0                 | -                     | -                        |
|             | Завхан      | 15.0                                   | 10.0                   | 8.0                  | -                     | 12.0                     |
|             | Увс         | -                                      | 5.0                    | 12.0                 | -                     | -                        |
|             | Ховд        | -                                      | -                      | 15.0                 | -                     | -                        |
|             | Дун         | 15.0                                   | 32.0                   | 118.0                | 5.0                   | 12.0                     |
| Хангайн бүс | Архангай    | -                                      | -                      | 5.0                  | -                     | 5.0                      |
|             | Баянхонгор  | 10.0                                   | -                      | 5.0                  | -                     | -                        |
|             | Булган      | 5.0                                    | -                      | -                    | -                     | 5.0                      |
|             | Орхон       | -                                      | 30.0                   | 117.0                | 36.0                  | -                        |
|             | Өвөрхангай  | -                                      | -                      | -                    | -                     | 5.0                      |
|             | Хөвсгөл     | 10.0                                   | -                      | 5.0                  | -                     | 5.0                      |
|             | Дун         | 25.0                                   | 30.0                   | 132.0                | 36.0                  | 20.0                     |
|             | Төв         | -                                      | -                      | -                    | -                     | -                        |
| Төвийн бүс  | Говьсүмбэр  | 5.0                                    | 2.0                    | 2.0                  | -                     | -                        |
|             | Дархан-Уул  | -                                      | -                      | -                    | 5.0                   | -                        |
|             | Дорноговь   | 8.0                                    | -                      | -                    | -                     | 5.0                      |
|             | Дундговь    | -                                      | 5.0                    | 5.0                  | -                     | -                        |
|             | Өмнөговь    | -                                      | -                      | 40.0                 | 5.0                   | -                        |
|             | Сэлэнгэ     | -                                      | 10.0                   | -                    | -                     | -                        |
|             | Төв         | -                                      | 5.0                    | -                    | -                     | 12.0                     |
|             | Дун         | 13.0                                   | 22.0                   | 47.0                 | 10.0                  | 17.0                     |
|             | Төв         | -                                      | -                      | -                    | -                     | -                        |
| Зүүн бүс    | Дорнод      | -                                      | 5.0                    | 5.0                  | -                     | -                        |
|             | Хэнтий      | 6.0                                    | 7.0                    | 20.0                 | -                     | 8.0                      |
|             | Сүхбаатар   | -                                      | -                      | 5.0                  | -                     | -                        |
|             | Дун         | 6.0                                    | 12.0                   | 30.0                 | -                     | 8.0                      |
| Бугд        |             | 59.0                                   | 96.0                   | 327.0                | 51.0                  | 57.0                     |

Эсгий, эсгий гутал, савхин гутал, оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн, гэрийн модон эдлэлийн үйлдвэрүүдэд түгзэмэл хэрэглэгддэг технологи ашиглах зорилт тавина.

4/ Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

- Зээлийн баталгаа гаргах, даатгалын үйлчилгээ үзүүлэх механизмыг бүрдүүлнэ.
- Олон улсын байгууллага, гадаад орнуудын хөнгөлөлттэй зээлийн тодорхой хэсгийг орон нутгийн үйлдвэрүүдийг хөгжүүлэхдээ чиглүүлнэ.

Импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн татварын ялгавартай бодлого баримтална. Орон нутаг дахь "Зөвлөгөөн ехег алба"-ны үйл ажиллагааг дэмжих, өргөжүүлнэ.

Бүтээгдэхүүний чанар сайжруулах, шинэ техник, технологи эзэмших, мэргэжлийн боловсон хүчин үр чадварыг дээшшуулэх, орчин үеийн техник, технологид тулгуурласан мэдээллийн сүлжээ байгуулахад олон улсын байгууллага, гадаад орнуудтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 9 дүгээр  
сарын 8-ны өдөр

Дугаар 199

Улаанбаатар  
хотОрон сууцны барилгыг  
эзэмшүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн ёмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь заалт, 30.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

ОХУ-ын эзээлийн хөрөнгөөр баригдаж Монгол-Оросын хувь нийлуулсан Улаанбаатар темер зам нийгэмлэгт ашиглагдаж байгаа 55065.0 ам.дервэлжин метр талбай бүхий 920 айлын сууцыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газрын эзэмшилд

Монгол Улсын  
Ерөнхий сайд Н.ЭНХБАЯРДэд бүтцийн  
сайд Б.ЖИГЖИД

2003 оны 10 дугаар сарын 1-ний дотор шилжүүлсүгэй.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 9 дүгээр  
сарын 8-ны өдөр

Дугаар 201

Улаанбаатар  
хот

Тогтоогд оөрчлөлт оруулах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

нийслэлийн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт тус бур 36 хүртэл, Баганур, Налайх дүүрэгт тус бур 30 хүртэл, Багахангай дүүрэгт 20 хүртэл (нормативаар ажиллах орон тоо орохгүй) байхаар тогтоосугай."

1. "Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захиргачийн ажлын албаны бүтцийг шинчлэн тогтоо тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 185 дугаар тогтооолын 1, 4 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

2. Төсвийн удирдлага, санхүүжилтийн тогтолцоо өөрчлөгджэх байгаатай холбогдуулан Нийтэлэг үйлчилгээний газар, Иргэний бүртэл, мэдээллийн албыг өөрийгөө санхүүжүүлэх хэлбэрээр ажиллуулах арга хэмжээ авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболдод уурэг болгосугай.

а/1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг дор дурдсанаар тогтоосугай;

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захиргачийн ажлын албаны бүтцийг шинчлэн тогтоо тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 185 дугаар тогтооолын 2 дугаар зүйл, 6 дугаар зүйлийн "д" заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

-Төрийн захиргаа, хууль зүйн хэлтэс;

Монгол Улсын  
Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР

-Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс;

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын  
Хэрэг эрхлэх  
газрын дарга

-Санхүү, здийн засаг, төрийн сангийн хэлтэс;

Н.ЭНХБАЯР

-Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс;

-Гадаад харицаа, хамтын ажиллагааны хэлтэс;

-Цэргийн болон гамшгаас хамгавлах штаб;"

б/4. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг 60 хүртэл, Улаанбаатар хотын Захиргачийн ажлын албаны орон тооны дээд хязгаарыг 35 хүртэл,

Ө.ЭНХТҮҮВШИН



2003 оны 9 дүгээр  
сарын 15-ны өдөр

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Дугаар 203

Улаанбаатар

Монгол Улсын төсвийн орлого,  
зарлагын ангилал батлах тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 12.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-ыг 1 дүгээр хавсралт, "Бүтээгдэхүүний еренхий ангилал"-ыг 2 дугаар хавсралт, "Төсвийн еренхиййн захирагчдын ангилал"-ыг 3 дугаар хавсралт, "Төсвийн орлогын нэр төрлийн ангилал"-ыг 4 дүгээр хавсралт, "Төсвийн орлого төвлөрүүлэгч байгууллагын ангилал"-ыг 5 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Батлагдсан төсвийн бүтээгдэхүүний еренхий ангид нийцүүлэн эрхлэх асуудлын салбар, хүрээний бүтээгдэхүүний дэд анги, нэр төрлийг тогтоож, жил тутмын бүтээгдэхүүн нийлүүлэлтийн

гэрээнд тусгаж байх эрхийг төсвийн еренхиййн захирагч нарт олгосугай,

3. Монгол Улсын төсвийн орлого, зарлагын ангилал шинчлэн баталсантай холбогдуулан бусад холбогдох журам, заавар, мэдээний маягтыг энхүү ангилалд нийцүүлэх арга хэмжээ авах, батлагдсан төсвийн ангиллыг 2004 оны төсвийн жилээс эхлэн нийтээр дагаж мөрдүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

Монгол Улсын  
Ерөнхий сайд

Н.ЭНХБАЯР

Санхүү, эдийн  
засгийн сайд

Ч.УЛААН

**Засгийн газрын 2003 оны 203 дугаар  
тогтооолын 1 дүгээр хавсралт**

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН  
ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ**

|         |   |   |
|---------|---|---|
| 2000000 | Нийт зардал   | Жижиг эд хогшил худалдан авах                       |
| 2100000 | Ажиллагаадын зардал                                 | Нормын болон дүрэмт хувцас,                         |
|         | Цалин, хөлс, нэмэгдэл урамшил<br>(менгэн хэлбэрээр) | зөвлөн здлэл  |
|         | Үндсэн цалин  | Хоол  |
|         | Үндсэн нэмэгдэл                                     | Эм, вакцин  |
|         | Бусад нэмэгдлүүд                                    | Ургал засвар  |
|         | Нийгмийн даатгалын шимтгэл                          | Төлбөр хураамж, жижиг татварууд                     |
|         | Тэтгэврийн даатгалын шимтгэл                        | Байрны түрээс                                       |
|         | Тэтгэмжийн даатгалын шимтгэл                        | Харуул, хамгаалалтын зардал                         |
|         | ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл                         | Банкны үйлчилгээний хураамж                         |
|         | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл                      | Еренхий боловсролын сургуулийн                      |
|         | Эрүүл мэндийн даатгалын хураамж                     | сурх бичиг хэвлүүлэх, худалдан авах                 |
|         | Бусад төрлийн даатгалын шимтгэл,                    | Төрийн өмнөөс хувийн хэвшлээр                       |
|         | хураамжууд  | гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр             |
| 2200000 | Бараа, үйлчилгээний хэрэглээ                        | Олон улсын гишүүний татвар                          |
|         | Гэрэл, цахилгаан                                    | Хөтөлбөр, арга хэмжээний зардал                     |
|         | Түлш, халаалт                                       | Бусад зардал  |
|         | Цэвэр, бохир ус                                     | Үндсэн хөрөнгийн ашиглалт                           |
|         | Тээвэр, шатахуун                                    | Хөрөнгө ашигласны төлбөр                            |
|         | Бичиг хэргийн материал                              | Үндсэн хөрөнгийн эзлэгдэл,                          |
|         | Шуудан, харилцаа холбоо                             | хорогдол  |
|         | Дотоод албан томилолт                               | Хүүгийн зардал                                      |
|         | Гадаад албан томилолт                               | Гадаадын этгээдэд төлөх хүү                         |
|         | Гадаад зочны зардал                                 | Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр                  |
|         | Ном, хэвлэл захиалах, худалдан авах                 | Засгийн газрын бус, дотоодын байгууллагад төлөх хүү |
|         | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага                       |   |
|         | Эрдэм шинжилгээний ажил хийх                        |   |



|         |   |   |
|---------|---|---|
|         | Улсын зээлзгээ, бондын хүү<br>Засгийн газрын ерийн бичгийн хүү<br>Банкны зээлийн хүү<br>Засгийн газрын байгууллага,<br>нэгжүүдэд төлөх хүү<br>Төсөөт байгууллагудын дансны<br>үлдэгдэл, хадгаламжид төлөх хүү<br>(ТСНД)<br>Бусад  | Ажилгүйдлийн тэтгэмж<br>Цэргийн тэтгэвэр<br>Тэтгэврийн нэхэн олговор<br>Эрүүл мэндийн даатгалас эмийн<br>үнийн хенгеллэлтэд олгох зардал<br>(биец хэлбэрээр)<br>Нийгмийн халамжийн зардал<br>Халамжийн тэтгэвэр<br>Жирэмсэн, амаржсан эхийн<br>тэтгэмж  |
| 2500000 | Татаас<br>Терийн ёмчийн ААН-дэд олгох<br>татаас<br>Эрчим хүчиний үйлдвэрүүдэд<br>олгох татаас<br>Нийтийн тээврийн үйлчилгээний<br>татаас<br>Орон нутгийн хэвлэл мэдээллийн<br>хэрэгслийн ажиллагааны татаас<br>Бусад татаас, шилжүүлэг<br>Хувийн хэвшлийн ААН-дэд олгох<br>татаас   | Нярай хуухдтэй эхийн тэтгэмж<br>Олон хуухдтэй эхийн тэтгэмж<br>Хуухдийн арчилгаваны тэтгэмж<br>Ихэр хуухдийн тэтгэмж<br>Бүтэн винчин хуухд үрчлэн авч<br>өвслөн тэтгэмж<br>Өндөр настан, ахмад дайчдад<br>олгох хенгеллт<br>Тахир дуттуу хүмүүст үзүүлэх<br>хенгеллт<br>Улсын баатар, партизануудад<br>үзүүлэх хенгеллт<br>Халамжийн бусад хенгеллт,<br>үйлчилгээ |
| 2600000 | Тусламж, шилжүүлэг<br>Гадаадын улс орнуудад үзүүлсэн<br>Ургал тусламж<br>Хөрөнгийн тусламж<br>Засгийн газрын бусад түвшний<br>нэгжүүдэд олгосон<br>Ургал тусламж<br>Бусад шатны төсөөт олгох<br>санхүүгийн дэмжлэг<br>Нийгмийн даатгалын санд<br>олгох татаас<br>Тер хариуцах иргэдийн эрүүл<br>мэндийн даатгалын хураамж<br>Тэтгэврийн нэхэн олговор<br>авагсдын нийгмийн<br>даатгалын шимтгэл<br>Бусад<br>Хөрөнгийн тусламж | Улсын баатар, партизануудад<br>үзүүлэх хенгеллт<br>Ахмад дайчдад олгох ног<br>удаагийн тэтгэмж<br>Бусад тэтгэмж<br>Ажил олгогчоос егех бусад тэтгэмж<br>Мөнгөн хэлбэрээр<br>Биец хэлбэрээр  |
|         | 2800000   | Бусад зардал<br>Хуүгээс бусад хэлбэрийн ёмчийн<br>зардал<br>Суваг ашигласны түрээс<br>Бусад<br>Нэр заагдаагүй бусад зардал<br>Ургал зардал  |
